



**МОНГОЛ УЛСЫН
ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА**

210646 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг,
Бага тойруу, Засгийн газрын IV байр,
Утас: 26-04-37, Факс: 32-32-66

2013.02.25 № 02/04 ЧАГ-САГ/2013/СТА-ТшЗ

Шатахууны тооцоо бодох тухай

Орон сууцны хороолол, дэд бүтэц төслийн 2012 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн тайлангийн аудитын явцад иргэн А.Баянтунгалагаас худалдан авсан Хьюндай старекс суудлын авто машин худалдан авч, засвар үйлчилгээнд 900,0 мянган төгрөг зарцуулсан зөрчил илэрлээ.

“Захиалагч байгуулагатай гэрээ байгуулахдаа гэрээний тусгай нөхцөлийн 5-д баталгаат засварын тусгай шаардлагад нэг жилээс доошгүй баталгаат засварын хугацаатай гэж заасныг үндэслэн тооцоо хийх, 18.1-д дотоод хяналтыг аж ахуйн нэгж, байгууллагын удирдлага хэрэгжүүлнэ” гэж заасныг тус тус зөрчсөн байна.

Төрийн аудитын тухай хуулийн “Үндэсний аудитын газрын бүрэн эрхийн тухай” 15 дугаар зүйлийн 1-ийн 12-т “Аудитын явцад илэрсэн төлбөр, зөрчлийг барагдуулах акт тавих, албан шаардлага өгөх” гэж заасныг үндэслэн ШААРДАХ НЬ:

Иргэн А.Баянтунгалагтай 900,0 мянган төгрөгийн тооцоог бодож, биелэлтийг гарган 2013 оны 4 дугаар сарын 10-ны дотор Үндэсний аудитын газарт хариу ирүүлэхийг Орон сууцны хороолол, дэд бүтэц төслийн зохицуулагч Ч.Доржготов, нягтлан бодогч Т.Золзаяа нарт хариуцуулав

АЛБАН ШААРДЛАГА



Ч.Доржготов

Нягтлан бодогч

Т.Золзаяа

070012